



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/72

Шивээговь сум

Коронавируст халдвар (Ковид-19)-ийн
эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, 29.1.6.ж, 29.1.6.л, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 115 дугаар “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоол, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 05/A/12 дугаар тушаал, Улсын онцгой комиссын 17 дугаар хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/142 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улсын хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хязгаарлалт тогтоох төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Улаанбаатар хот болон халдварын голомтын бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаан (зайлшгүй албан томилолт, эрүүл мэнд, ар гэрийн гачигдал, хүнс, өвс, тэжээл тээвэр, шатахуун тээвэр, уул уурхайн зөвшөөрөгдсөн ээлж солих)-оос бусад тохиолдолд иргэд, тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаагаар хязгаарласугай.

3. Сумын хэмжээнд олон нийтийг хамарсан урлаг, соёлын тоглолт, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, нийтийн эзэмшлийн гудамж, талбай, тоглоомын талбайд бөөгнөрөл үүсгэхийг хориглосугай.

4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан үйл ажиллагааг нь хязгаарлаагүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, иргэдийг Коронавируст халдвар (Ковид-19)-ийн эсрэг дархлаажуулалтад хамруулах, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлээгүй, QR код байршуулаагүй, халдвар хамгааллын дэглэм, холбогдох хууль, дүрэм,

42121*436

журмыг зөрчсөн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Сувданцэцэг/, Мал эмнэлгийн улсын байцаагч /Ш.Буяннэмэх/, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/ нарт үүрэг болгосугай.

5. Улаанбаатар хот болон халдварын бүс нутгаас ирж буй иргэнийг нэвтрэхэд нь ПСР шинжилгээ болон аймгийн хяналтын постонд өгсөн түргэвчилсэн шинжилгээний хариуг үндэслэж, сумын хяналтын постоор нэвтрүүлэхийг Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/-т үүрэг болгосугай.

6. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг 09:00-22:00 цагийн хооронд байхаар тогтоож, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн /Д.Эрдэнэтулга/, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/ нарт үүрэг болгосугай.

7. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд халдвар хамгааллын дэлэмийг чанд мөрдүүлж зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Энхриймаа/-д үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.


9. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/66 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2021 оны 05-р сарын 07-ны өдрийн 1172 дугаар захирамжийн хавсралт



Хязгаарлалт тогтоох төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааны жагсаалт

№	Үйл ажиллагаа
1	Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага /нийт ажилтан, албан хаагчдыг 50/50 харьцаагаар, ердийн цагийн хуваарийн дагуу ажиллуулах/
2	Жагсаал, цуглаан, уралдаан тэмцээн
3	Аялал зугаалга, хурим найр, цайллага, хүлээн авалт
4	Бүх төрлийн баар, цэнгээний газар
5	Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа
6	Цахим ба автомат тоглоомын газар болон бүх төрлийн тоглоомын төв
7	Сургалтын төв
8	Соёл, урлагийн арга хэмжээ, үзвэр үйлчилгээ
9	Алжаал тайлах төв
10	Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, спиннинг
11	Саун, бассейн
12	Амралт, жуулчны бааз
13	Шашны зан үйл, сүм хийд, мөргөлийн газрууд
14	Олимп, тив дэлхий олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ
15	Нийтийн бүжиг ба бүх төрлийн клуб